

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/095/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг: erdenetsogt.v@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 261740 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn Нийслэл-Аудит ХХК-ийн захирал: Т.Сугарсүрэн Утас: 70110095 Цахим хаяг: info@niislelaudit.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГА Г.ЦОГТСАЙХАН ТАНАА

2025.03.25 № 07/1176
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Тухайлбал:

- Жилийн эцэст дансны авлагын 964.3 сая төгрөгийн үлдэгдлээс нэр бүхий 30 байгууллагын 429.5 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Хувь хүнээс 2021 онд худалдан авсан 400.61 мкв талбай бүхий 670.9 сая төгрөгийн байрыг хөрөнгөөр бүртгээгүй, хувь хүнээс авах авлагаар бүртгэж тайлагнасан зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалтуудтай нийцээгүй бөгөөд эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээ”-ний тухай 211 дүгээр тогтоол, Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 242 дугаар тушаалаар баталсан “Төрөөс хариуцах цэвэр, бохир усны хэрэглээг зохицуулах журам”-ыг хэрэгжүүлэхдээ зохицуулах хороо нь Ус сувгийн удирдах газар, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч хувийн хэвшлийн 78 аж ахуйн нэгжийн хоорондын тооцоогоор төрөөс хариуцах цэвэр бохир усны төлбөрийг 7,282.9 сая төгрөгөөр давхардуулан олгосон байсан. Энэхүү давхардуулан олгосон төлбөрийг аж ахуйн нэгж байгууллагаас эргүүлэн татах үүргийг Зохицуулах хорооны удирдлагад хүргүүлсэн бөгөөд уг тооцоо нь өмнөх оноос 1,291.0 сая төгрөгөөр буурч 804.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант оны нийт орлогыг 2,456.8 сая төгрөг, нийт зардлыг 2,456.8 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 2,498.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 2,240.5 сая төгрөгийн зардал гаргаж, 258.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хороо нь 2024 онд үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлангаар 4 зорилтын хүрээнд 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 98.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. B.

Ц.НАРАНЧИМЭГ



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	536,417,113.71	788,726,304.77
1.1.2	Дансны авлага	675,155,905.69	964,298,058.97
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	96,800.02	983,250.00
1.1.4	Бусад авлага	2,187,083,011.29	675,155,905.69
1.1.6	Бараа материал	21,505,383.22	27,580,286.22
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,420,258,213.93	2,456,743,805.65
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	217,958,864.55	213,053,749.85
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	217,958,864.55	213,053,749.85
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,638,217,078.48	2,669,797,555.50
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	2,095,869,839.14	804,852,810.95
2.1.1.3	Татварын өр	7,754,238.48	663,816.84
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,103,624,077.62	805,516,627.79
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,103,624,077.62	805,516,627.79
2.3	Эздийн өмч	20,000.00	20,000.00
2.3.1	Өмч: төрийн	20,000.00	20,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	8,029,219.75	0.0
2.3.9	Хуримтлагдсан ашиг	1,526,543,781.11	1,864,260,927.71
2.3.11	Эздийн өмчийн дүн	1,534,593,000.86	1,864,280,927.71
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,638,217,078.48	2,669,797,555.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

<i>/төгрөгөөр/</i>			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,565,029,088.34	2,491,042,585.71
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	1,565,029,088.34	2,491,042,585.71
8	Бусад орлого	110,459,750.00	7,641,438.29
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,654,295,256.97	2,240,487,355.28
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	21,193,581.37	258,196,668.72
20	Татварын дараах ашиг (алдагдал)	21,193,581.37	258,196,668.72
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	21,193,581.37	258,196,668.72
23	Бусад дэлгэрэнгүй орлого		71,491,258.13
24	Орлогын нийт дүн	21,193,581.37	328,687,926.85
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйлажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,645,295,620.10	2,437,302,787.13
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,456,612,170.10	2,421,566,609.84
1.1.6	Бусад мөнгөн орлого	188,683,450.00	15,736,177.29
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,664,526,736.28	2,184,993,596.07
1.2.1	Ажиллагчдад төлсөн	805,830,019.72	1,173,698,618.46
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	111,700,016.17	164,448,313.41
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	22,621,018.00	9,666,607.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	7,649,053.44	7,118,314.93
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	10,239,778.00	31,793,567.50
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	81,162,556.52	117,796,468.37
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,079,180.00	115,830.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	623,245,114.43	680,355,876.40
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(19,231,116.18)	252,309,191.06
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(19,231,116.18)	252,309,191.06
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	555,648,229.88	536,417,113.71
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	536,417,113.71	788,726,304.77

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00		1,531,842,464.74	1,531,862,464.74
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(26,492,265.00)	(26,492,265.00)
Залруулсан үлдэгдэл	20,000.00	-	1,505,350,199.74	1,505,370,199.74
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			21,193,581.37	21,193,581.37
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		8,029,219.75		8,029,219.75
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00	8,029,219.75	1,526,543,781.11	1,534,593,000.86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
Залруулсан үлдэгдэл	20,000.00	8,029,219.75	1,534,573,000.86	1,534,593,000.86
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			258,196,668.72	258,196,668.72
Зарласан ногдол ашиг			-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		63,462,038.38		63,462,038.38
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000.00	71,491,258.13	1,792,769,669.58	1,864,280,927.71

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
A	Борлуулалтын орлого	1,675,488.8	2,456,789.0	2,498,684.0	(41,895.0)	101.7
5	Нийт орлого	1,675,488.8	2,456,789.0	2,498,684.0	(41,895.0)	101.7
6	Үүнээс: Цэвэр орлого	1,565,029.1	2,456,789.0	2,491,042.6	(34,253.6)	101.4
7	Бусад орлого	110,459.8		7,641.4	(7,641.4)	-
B	Нийт зардал	1,654,295.3	2,456,789.0	2,240,487.4	216,301.6	91.2
8	Ерөнхий ба удирдлагын зардал	1,251,226.7	2,022,152.7	1,831,562.4	190,590.2	90.6
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал		799,727.1	1,336,704.0	1,287,296.8	49,407.2	96.3
9	Үндсэн цалингийн зардал	799,727.1	872,400.0	806,104.3	66,295.7	92.4
10	Орон тооны бус гишүүд		64,800.0	45,000.0	19,800.0	69.4
11	Нэмэгдэл цалин, урамшуулал		331,920.0	344,441.1	(12,521.1)	103.8
12	Ажилчдын өдрийн хоол, унааны хөнгөлөлт		67,584.0	43,752.0	23,832.0	64.7
13	Гэрээт ажилтаны цалин			14,429.5	(14,429.5)	-
14	Нэмэлт санхүүжилтийн цалин /Эмзэг байдлын шинжилгээ хийхэд шаардлагатай ундны усны чанарын өгөгдөл боловсруулах/			15,255.0	(15,255.0)	-
15	Шагнал урамшуулал			18,315.0	(18,315.0)	-
Нийгмийн даатгалын шимтгэл, татвар хураамж		183,869.3	180,455.0	163,561.9	16,893.2	90.6
16	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	109,151.6	180,455.0	163,561.9	16,893.2	90.6
17	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	74,717.7				-
Байр ашиглалттай холбоотой зардал		109,997.1	129,000.0	143,351.6	(14,351.6)	111.1
22	Ашиглалтын зардал	10,030.0		8,346.0	(8,346.0)	-
23	Түрээсийн зардал	99,967.1	129,000.0	135,005.6	(6,005.6)	104.7
Хангамж, бараа материалын зардал		35,026.5	176,102.9	95,480.2	80,622.6	54.2
19	Бичиг хэргийн зардал	13,632.6	11,905.0	13,575.6	(1,670.6)	114.0
20	Шуудан холбооны зардал	7,400.1	9,855.4	12,625.4	(2,770.0)	128.1
24	Тээвэр, шатахууны зардал	13,993.8	27,480.5	22,933.2	4,547.3	83.5
25	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйл		6,856.0	6,609.5	246.5	96.4
26	Тавилга		111,800.0	31,839.3	79,960.8	28.5
27	Урсгал засвар		8,206.0	7,897.3	308.7	96.2
Томилолтын зардал		120,527.5	171,804.7	118,842.1	52,962.6	69.2
28	Дотоод албан томилолт		62,244.0	38,923.0	23,321.0	62.5
29	Гадаад томилолт		109,560.7	79,919.1	29,641.7	72.9
Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,079.2	28,086.0	23,029.8	5,056.2	82.0
30	Даатгалын зардал	2,079.2		493.0	(493.0)	-
31	Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		28,086.0	22,536.8	5,549.2	80.2
Бараа үйлчилгээний бусад зардал		403,068.6	434,636.4	408,924.9	25,711.4	94.1
32	Эрдэм шинжилгээний судалгааны ажил		197,000.0	68,959.5	128,040.5	35.0
33	Мэдээлэл сурталчилгааны ажил		24,030.0	14,684.0	9,346.0	61.1
34	Сургалтын зардал		26,400.0	7,788.1	18,611.9	29.5
35	Төвлөрсөн арга хэмжээ		50,000.0	38,662.4	11,337.6	77.3
36	Гадаад болон олон улсын байгууллагын гишүүнчлэлийн хураамж		5,106.4		5,106.4	-
37	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал		132,100.0	132,548.6	(448.6)	100.3
38	Бусад зардал	403,068.6		146,282.4	(146,282.4)	-

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Г	Татвар төлөхийн өмнөх ашиг	21,193.6		258,196.7	(258,196.7)	-
21	Цэвэр ашиг	21,193.6		258,196.7	(258,196.7)	-
22	Ажиллагсдын тоо	25	32	28	4	87.5

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нийт 1,120.6 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 9.8 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,110.8 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дотоод, гадаад томилолтын зардлыг томилолтын хуудас баталгаажуулахгүй, гүйцэтгэлийн тайлангүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу олгосон	1	10,284.0			1	10,284.0						
Тайлант хугацаанд харилцагч байгууллагуудын зохицуулах үйлчилгээний 964,298.0 мянган төгрөгийн авлагаас нэр бүхий 30 байгууллагын 429,521.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	429,521.0			1	429,521.0						
Хорооны орон тооны бус зөвлөлийн нэр бүхий 3 гишүүнд 7,500.0 мянган төгрөгийн 13 дахь сарын цалин урамшуулал олгосон, мөн тайлант хугацаанд 2 сар ажилласан нэг ажилтанд 1,865.9 мянган төгрөгийн 13 дахь сарын цалинг тус тус олгосон	1	9,365.9	1	9,365.9								

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Хорооны орон тооны бус зөвлөлийн нэр бүхий 3 гишүүний үндсэн ажлаас гадуур давхар ажил гүйцэтгэсэн цалингаас сар бүр ХХОАТ-н хөнгөлөлт тооцсон байгаа нь холбогдох хуулийн заалтад нийцээгүй	1	528.0	1	528.0								
Зохицуулах Хороо нь 2021 онд 670,934.0 мянган төгрөгөөр хувь хүнээс худалдаж авсан 400.61 мкв талбай бүхий байрыг үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гараагүй шалтгаанаар үндсэн хөрөнгөөр бүртгээгүй, авлагаар бүртгэж тайлагнасан байна.	1	670,934.0			1	670,934.0						
Дүн	5	1,120,632.9	2	9,893.9	3	1,110,739.0	-	-	-	-	-	-

3.2 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 894.7 сая төгрөгийн зөрчил илэрснээс 894.7 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 2,544,475.0 мянган төгрөгийн 16 мэдээ байршуулахаас 894,689.2 мянган төгрөгийн 10 мэдээ байршуулаагүй байна.	1	894,689.2			1	894,689.2		
Дүн	1	894,689.2			1	894,689.2		

